

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ
2024 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН**

2025.01.03

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 11/67, “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 14/88, “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/14 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааварт нийцүүлэн зохион байгуулан ажиллалаа.

1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувийн хамт ерөнхий байдлаар дүгнэн бичнэ.

2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-ын 2023 оны 11/67 тогтоолын дагуу дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 85,764.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. Дүүргийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 14/88 дугаар тогтоолоор төсөвт нэмэлт өөрчлөлт орж, 126,238.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ багцад хуваагдаж батлагдсантай холбоотойгоор төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж 242 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсон.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая.төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	87630.1	183
2	Дахин зарлаж, он дамжсан	4500.0	1
3	ХАА-г зохион байгуулсан, амжилтгүй болж хөрөнгө татагдсан	6898.9	49
4	Хэрэгжээгүй /захиалга ирээгүй, ҮХ байгуулагдсан/	27102.5	8
5	Цуцлагдсан	106.6	1
ДҮН		126238.1	242

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснээр 3071.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-ын 2023 оны 11/67 тогтоолын дагуу дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 1690.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	1690.8	7
ДҮН		1690.8	7

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 39.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1489, 2024 оны А/940 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн Төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 багцтай төсөл арга хэмжээ, 5000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх тус тус шилжиж ирсэн.

Дээрх эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулан ажиллаа.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	400.0	3
2	ХАА-г зохион байгуулсан, амжилтгүй болж хөрөнгө татагдсан	5000.0	1
ДҮН		5400.0	4

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 44.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион байгуулахаар 2024

оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2660.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ тусгагдсан. 2024 оны 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10 дугаар саруудад тус тус төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж 24699.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр өөрчлөгдсөн. Үүнээс 2024 оны 11 дүгээр сард "Халтиргаа гулгаа арилгах элс, давс худалдан авах" 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нэг төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ-т шилжүүлснээр 24199.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр өөрчлөгдсөн. Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ багцад хуваагдаж батлагдсантай холбоотойгоор төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж 73 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсон.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	12419.5	52
2	Дахин зарлаж, он дамжсан	220.0	3
3	ХАА-г зохион байгуулсан, амжилтгүй болж хөрөнгө татагдсан	746.5	3
4	Хэрэгжээгүй /захиалга ирээгүй, ҮХ байгуулагдсан/	8353.0	8
5	Хэрэгжээгүй /захиалга ирээгүй, ҮХ байгуулагдаагүй/	2460.0	7
ДҮН		24199.0	73

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 79.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 386.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

Төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт түүний хэрэгжилт

Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын хүрээнд нийт 56 үнэлгээний хороо Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан бөгөөд 2024 онд хэрэгжүүлбэл зохих худалдан авах ажиллагааны хэрэгжилт нэгдсэн дүнгээр доорх байдалтай байна.

Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт (2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

Үзүүлэлт	ДТХО		ДОНХС		Бусад		НТХО		нийт		эзлэх			
	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	хувь		
ХАА-г бүрэн зохион байгуулсан	183	87,630.08	7	1,690.84	52	12,419.52	3	400.00	245	102,140.44	302	92.6%		
Тендерийн шатанд, дахин зарласан	1	4,500.00			3	220.00			4	4,720.00				
Амжилтгүй болж хөрөнгө татагдсан	49	6,898.92			3	746.50	1	5,000.00	53	12,645.42				
Захиалга ирээгүй, ҮХ байгуулагдсан	8	27,102.52			8	8,353.03			16	35,455.55			16	4.9%
Захиалга ирээгүй, ҮХ байгуулагдаагүй					7	2,460.00			7	2,460.00			7	2.1%
Цуцлагдсан	1	106.61							1	106.61	1	0.3%		
ДҮН	242	126,238.13	7	1,690.84	73	24,199.05	4	5,400.00	326	157,528.02	326	100%		

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 3541.5 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

Худалдан авах ажиллагааг 100 хувь худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан бөгөөд тендерийн Үнэлгээний хороодод тус албаны бүх албан хаагчид санамсаргүй байдлаар сонгогдон нарийн бичгийн даргаар ажиллаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерийн урилга, баримт бичиг болон үр дүнгийн мэдээллийг тухай бүрт цахим системээр дамжуулан ил тод, нээлттэй байршуулж иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд:

- Дүүргийн Засаг даргын баталсан хөрөнгө оруулалтын Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын 2024 оны жилийн төлөвлөгөөг www.tender.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын www.sbd.gov.mn, www.shilendans.gov.mn, www.report.ub.procurement.mn цахим хуудсуудад, мөн дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.
- Батлагдсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, явц, үр дүнгийн талаарх мэдээ тайланг www.tender.gov.mn, www.shilendans.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын www.sbd.gov.mn, www.report-ubprocurement.mn цахим хуудсууд болон дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны хамт тусгана.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн нь зохион байгуулж байгаа тендерт шаардлагад нийцээгүй тендер ирүүлж байгаа болон нэг ч тендер ирэхгүй байгаа нь гол шалтгаан болж байна.

1.3 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн тухай

2024 онд нийт 245 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан байна. Эдгээр төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд бүрэн хийж захиалагчид үнэлгээний дүгнэлтийг хүргэж ажилласан болно.

Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил түүнийг хэрхэн засаж залруулсан тухай /тус бүрээр/

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад зөрчил гараагүй болно.

1.4 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад “Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх” 5670.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендер зарласан шатанд ШӨХТГ-т гомдол гарсан. Үүний улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хүртэл сунгасан. Тус төсөл арга хэмжээний амжилтгүй болсон багцуудын тендер шалгаруулалтыг дахин зарлах шатанд ШӨХТГ-т гомдол гарсан ба тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүртэл сунгасан ба үнэлгээ хийгдэж 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр үр дүн гарсан. Тус төсөл арга хэмжээний 8, 11 дүгээр багцуудад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн үр дүнд оролцогчоос СЯ-д гомдол гаргаж түдгэлзүүлсэн. Дахин үнэлж 8 дугаар багцын үр дүн хэвээр гарч, 11 дүгээр багцын худалдан авах ажиллагааг дахин зарласан.

“1-р хороо, 23-р байрны дээвэр засвар”-ын 243.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний үр дүнд 2024 оны 02 дугаар сарын 1-ний өдөр гарсан. Тус тендерийн үр дүнд оролцогчоос СЯ-д гомдол гаргасан тул холбогдох материалыг шалгуулж, дахин үнэлгээ хийж, мэдэгдлийг хүргүүлсэн болно.

“Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хүчилтөрөгчийн системийн угсралт суурилуулалтын ажил”-ын 1278.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендер зарласан шатанд ШӨХТГ-т гомдол гарч уг төсөл арга хэмжээг цуцалсан байсныг дахин зарласан.

“Нэгдсэн эмнэлгийн сүлжээний хамгаалалтын төхөөрөмж” нийлүүлэх 96.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, “Нэгдсэн эмнэлгийн серверийн өрөөний тоног төхөөрөмж” нийлүүлэх 97.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарсан. Эдгээр ажлын үр дүнд оролцогчоос СЯ-д гомдол гаргасан тул дахин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно.

“6-р хороо 73/9, 73/10, 11-р хороо 901, 902-р байрны лифт засвар”-ын 910.0 сая төгрөгийн, “8-р хороо, Орон сууцны лифт засвар”-ын 170.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний тендер зарлагдсан шатанд буюу 2024 оны 08 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гарсан тул холбогдох материалыг бүрдүүлэн өгч, шалгуулж нээлтийн хугацааг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр болгон сунгасан. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан.

“Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг сайжруулж, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх” 684.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендер зарлагдсан шатанд буюу 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт (Монополын эсрэг газар) гомдол гарсан тул холбогдох материалыг бүрдүүлэн өгч, шалгуулсан. Нээлтийн хугацааг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр болгон сунгасан. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан.

“75-р цэцэрлэг барилга буулгалт”-ын 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендерийн үр дүнд оролцогчоос 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр СЯ-д гомдол гаргасан ба үр дүнд гаргасан шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн болно.

“Боловсролын байгууллагын зураг, төсөв боловсруулах” 70.0 сая төгрөгийн, “Боловсролын барилгын зураг, төсөв боловсруулах” 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний тендерийн үр дүнд оролцогчоос 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр СЯ-д гомдол гаргасан ба дахин үнэлгээ хийж, мэдэгдлийг хүргүүлсэн болно.

“10-р хороо, 42а байрны дээвэр засвар”, “10-р хороо, 42б байрны дээвэр засвар”, “10-р хороо, 42в байрны дээвэр засвар” тус бүр нь 54.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний тендерийн үр дүнд оролцогч компаниас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр СЯ-д гомдол гаргасан ба дахин үнэлж, мэдэгдлийг хүргүүлсэн болно.

Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүнд, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах

Дотоодын бараа бүтээгдэхүүний давуу эрхийн зөрүү тооцох зорилгоор Тендерийн баримт бичиг бүрт хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу шаардлагыг тусгаж ажиллалаа. 2024 онд 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Халтиргаа гулгаа арилгах элс, давс худалдан авах”

төсөл арга хэмжээний худалдан авалт буюу 449.4 сая төгрөгийн 555 тн техникийн давсыг Эм Би Эм Ти Эм констракшн ХХК-с дотоодын худалдан авалт хийсэн болно.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаарх дүгнэж ирүүлнэ.

Тус алба нь 2024 онд нийслэл, дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжих нийт 157528.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 326 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажилласнаас 102140.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 245 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерийн системээр бүрэн зохион байгууллаа. Мөн цахим тендерийн урилга, үр дүн, гүйцэтгэгчийн гэрээний мэдээллийг тухай бүр худалдан авах ажиллагааны системд мэдээлж, нийтэд ил тод нээлттэй ажиллалаа.

2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлнэ.

Захиалагчийн хувьд ерөнхий гэрээгээр хэрэгжих худалдан авалт байгаагүй тул цахим дэлгүүр ашиглаагүй болно.

ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1. Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан талаар тусгана.

Дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн хэмжээний сургууль, цэцэрлэгүүдийн захирал, дарга нарт 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан сургалтад тус албаны зүгээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл хүргэж ажиллалаа.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсарган ирүүлнэ.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрыг худалдан авах ажиллагаатай холбоотой бүх талын мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиалагч болох дүүргийн Засаг даргын Тамгын газартай тус алба нь байнга хамтран ажиллаж “Худалдан авах ажиллагааны захиалгын маягт”-ын дагуу төсөл арга хэмжээ бүрийн захиалга даалгаврыг хүлээн авч боловсруулан, мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллалаа.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, САНАЛ

4.1. Захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлтийг тодруулан гаргаж тавина.

2024 онд нийт 245 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны худалдан авах ажиллагааны журмын сонголт дараах байдалтай байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 180 төсөл арга хэмжээ;
- Харьцуулалтын аргаар 64 төсөл арга хэмжээ;
- Шууд худалдан авалт 1 төсөл арга хэмжээ тус тус зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 3541.5 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

4.2. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан тухай

Гэрээний хэрэгжилтийг захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар тус тус хяналт тавьж ажиллаж байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА